

## Product Data Sheet

Edition: 03/2008

Version No. 05

Sika® 102

# Sika® 102

## Түргэн бэхждэг усны бөглөө

### Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sika 102 нь найрлагандаа хлорид агуулаагүй, хэрэглэхэд бэлэн зуурмаг. Усны хольж зуурмагц маш хүчтэй, хурдан бэхждэг түр зуурын усны бөглөө болно.

### Хэрэглээ:

Туннель, дамжуулах хоолой, метро, далан, барилгын суурь, усан сан зэрэг газрын бетон болон ган төмөр эдлэлийн заагаар даралттай ус гарах болон шүүрч нэвтэрч байгаа тохиолдолд хэрэглэнэ.

### Бүтээгдэхүүний давуу талууд

- Хэрэглэхэд хялбар бэлэн зуурмаг – Зөвхөн ус нэмэх шаардлагатай
- Тусгай төрлийн багаж тоног төхөөрөмжүүд шаардагдахгүй
- Өндөр бат бэхтэй, маш хурдан хугацаанд бэхждэг
- Барьцалдан наалдах чадвар сайн
- Ус нэвчилтийг зогсоож, нэвчилтийг тэсвэрлэх гайхамшигтай чадвартай
- Хагарч ан цав үүсэхгүй
- Хлорид агуулаагүй
- Зэвэрдэггүй

### Бүтээгдэхүүний мэдээлэл

Хэлбэр / Өнгө

Нунтаг / Саарал

Сав баглаа боодол

2 ба 5 кг-ийн ууттай

### Хадгалалт

Хуурай, сэрүүн, хаалттай орчинд сав баглааг онгойлгоогүй, бүрэн бүтэн байгаа тохиолдолд үйлдвэрлэсэн хугацаанаас хойш 6 сар хадлагах боломжтой.

Construction



## Техникийн мэдээлэл

---


Нягт	~ 1,25 кг/л (нунтаг бүтээгдэхүүний нягт) ~ 2 кг/л (шингэн зуурмагын нягт)
Хольцын харьцаа	Нунтаг Sika 102 : Ус = 1 : 0,20 (жинд хамааран) Нунтаг Sika 102 : Ус = 1 : 0,30 (эзлэхүүнд хамааран)
Бэхжилт авч эхлэх хугацаа	(+27°C орчинд) 60 – 90 секунд
Гүйцэтгэлийн температур	Хамгийн багадаа +10°C / хамгийн ихдээ +40°C

---

## Хэрэглээ

---

### Хэрэглээ



1. Ус нэвтэрч буй бетон болон хадны хэсгийг V хэлбэр гарган зүс. Гадаргуу дээрх сул, хөдөлгөөнтэй, бутрамтгай хэсгүүдийг аваад Sika 102 шавараа түрхэхээс өмнө усаар цэвэрлэх шаардлагатай.
  2. Sika 102 шавараа V хэлбэрийн зүсэлтийн гадна талаас усны урсалт ирж буй гол төв рүү чиглүүлэн түрхэнэ (ус хүчтэй ундарч байгаа хэсгээс эхлүүлэн). Ус ундарч буй болон шүүрч буй хэсэгт шавараа хэсэг хугацаанд шахаж өгч барьцалдуулаад, дараа нь гадаргууг тэгшилнэ.
  3. Хэрэв усны даралт их гарч байгаа газарт эхлээд модон бөглөөгөөр бөглөөд түүний дээгүүр Sika 102 шавараар шавардаж битүүлэхийг санал болгож байна.
- 

### Анхаарах зүйлс / Хязгаарлалтууд

- Sika 102 шавараа бага бага хэмжээтэйгээр устай хольж зуурахыг зөвлөж байна. Хатууралт бэхжилт маш хурдан явагддаг тул их хэмжээтэй зуурсан тохиолдолд бүгдийг нь хэрэглэж амжихгүй хатах боломжтой
  - Sika 102 бүтээгдэхүүнийг уснаас өөр элс, цемент, бетоны нэмэлт зэрэг материалуудтай хольж болохгүй
-

---

## Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны мэдээлэл

---

**Байгаль орчин** Хаягдлыг усанд зайлуулж болохгүй

---

**Тээвэрлэлтийн ангилал** Хоргүй

---

**Хаягдлыг зайлуулах** Харьяалах орон нутгийн хууль дүрмийн дагуу

---

### Анхаарах зүйлс

- Илүү гарсан Sika 102-ийг өөрийнх нь уутанд хийж баглах ёстой.
  - Sika 102 нь цементэн суурьтай учраас шүлтлэг бүтээгдэхүүн юм. Иймээс ус бүтээгдэхүүнийг хэрэглэхдээ хувийн хамгаалах хэрэгсэл болон бээлий өмсөх хэрэгтэй. Хэрэв нүд рүү орсон тохиолдолд тэр даруй цэвэр усаар сайтар зайлах хэрэгтэй.
- 

### Чухал санамжууд

- Бүтээгдэхүүний хаягдлыг ус болон хөрсөнд хаяж болохгүй, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хаягдал устгах цэг талбайд устгана.
  - Аюулгүй ажиллагаа, физик шинж чанарууд болон байгаль орчинтой холбоотой бусад мэдээллүүд Эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны зааварчилгаанд тусгагдсан болно.
- 

### Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

---

### Sika Limited (Vietnam)

Head Office:  
Nhon Trach 1 Industrial Zone,  
Nhon Trach Dist., Dong Nai Prov.  
Tel: (84-61) 3560 700  
Fax: (84-61) 3560 699



**Sika**®